



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2020 оны 01 сарын 09 өдөр

Дугаар

A/05

Улаанбаатар хот


Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Нийслэлийн 2020 оны төсөв батлах тухай" 29/31 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2019 оны 09/36 дугаар тогтоол, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар хэсгийн 3.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын ногоон байгууламжийн ажлын судалгааг хийх, нийтийн эзэмшлийн болон хязгаарлагдмал, тусгай хэрэгцээний ногоон байгууламжийн өдөр тутмын арчилгаанд агротехнологийн хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх, мэргэжлийн заавар зөвлөгөө өгөх, зөрчил дутагдлыг арилгуулах үүрэг бүхий зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт ёсоор байгуулсугай.

2. Дээрх ажилд шаардагдах төсвийг 2 дугаар хавсралт ёсоор баталсугай.


3. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажиллахыг Үнэлгээний хороо /М.Гансэлэм/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



• 1110300015 •

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны *Август* сарын *09* өдрийн
А/05 тушаалын *1 дүм* хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	М.Гансэлэм	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Гишүүд	Э.Уянга	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
	Д.Лувсанчимэд	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Дотоод хяналтын хэлтсийн мэргэжилтэн
	Н.Энхбат	Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 2-р хороо, Чоймболын гудамж 55-64 тоотод оршин суугч иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Д.Сүхбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн хэлтсийн мэргэжилтэн

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2020 оны *дүүргийн* сарын *24* өдрийн
1105 тушаалын *дүүргийн* хавсралт



НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТЫН
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ТӨСӨВ

№	Төсөл арга хэмжээний нэр	2020 онд санхүүжих дүн /сая. Төгрөг/
1	Сүхбаатар, Баянзүрх дүүрэгт хяналт тавих зөвлөх үйлчилгээний ажил	50.0
2	Чингэлтэй, Хан-Уул дүүрэгт хяналт тавих зөвлөх үйлчилгээний ажил	50.0
3	Баянгол, Сонгинохайрхан дүүрэгт хяналт тавих зөвлөх үйлчилгээний ажил	50.0
	Дүн	150.0